



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/419

Улаанбаатар хот

Г Сургалт зохион байгуулах, зардал батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах Ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, зохион байгуулалтын зураглалыг гуравдугаар, сургалтад шаардагдах зардлыг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалаар баталсан зардал болох сургуулийн өмнөх болон бага боловсролын багш нарын сургалтын 325,576,900 (Гурван зуун хорин таван сая таван зуун далан зургаан мянга есөн зуун) төгрөгийн зардлыг Дэлхийн банкны санхүүжилттэй “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөс, Байгалийн ухаан, технологи, математикийн багш нарын сургалтын 139,696,500 (Нэг зуун гучин есөн сая зургаан зуун ерэн зургаан мянга таван зуун) төгрөгийн зардлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслөөс, Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, 6-12 дугаар ангийн (байгалийн ухаан, технологи, математикийн багшаас бусад) багш нарын сургалтын 436,087,400 (Дөрвөн зуун гучин зургаан сая хоёр наян долоон мянга дөрвөн зуун) төгрөгийн зардлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Эдийн засгийн хүндрэлтэй үеийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах” төслөөс тус тус санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т зөвшөөрсүгэй.

3. Сургалт зохион байгуулах “Сургагч багш” нарын амралтын зохицуулалтыг хангаж, үндэсний сургагч багшийн сургалтад бүрэн хамруулах, мөн орон нутгийн сургалтад үндэсний сургагч багшаар ажиллуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Боловсролын их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Мандах, Монгол Улсын Их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар болон ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Багш нарыг “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сэдэвт сургалтад бүрэн хамруулж, оролцуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

0901368

5. Сургалтын зохион байгуулалтыг удирдлагаар ханган ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга, Ажлын хэсгийн ахлагч Т.Ням-Очирт даалгасугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ